

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2026/020/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2026 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нармандах

Утас: 7058-4204, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Батжаргал

Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5-7
3. Аудитын илрүүлэлт	08-09
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	09

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4203

2026.03.13 № 347

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гурванзагал Хөгжил ОНӨААТҮГ нь сүүлийн 3 жил алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглал эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

2126050201

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	925,456.00	5,245,993.18
31	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	728,756.00	5,049,293.18
31200	1.1.1.02 Банкинд байгаа бэлэн мөнгө	728,756.00	5,049,293.18
31210	1.1.1.02.01 Төгрөг	728,756.00	5,049,293.18
31213	1.1.1.02.01.03 Арилжааны банк дахь	728,756.00	5,049,293.18
35	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	196,700.00	196,700.00
35400	1.1.5.04 Хангамжийн материал	196,700.00	196,700.00
35420	1.1.5.04.02 Аж ахуйн материал	196,700.00	196,700.00
2	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	56,237,711.23	41,116,480.30
39	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	56,237,711.23	41,116,480.30
39200	1.2.2.02 Биет хөрөнгө	56,237,711.23	41,116,480.30
39201	1.2.2.02.01 Барилга, байгууламж, орон	79,418,310.00	79,418,310.00
39202	1.2.2.02.02 Хуримтлагдсан элэгдэл	(62,451,699.99)	(64,893,930.92)
39203	1.2.2.02.03 Авто-тээврийн хэрэгсэл	69,312,500.00	69,312,500.00
39204	1.2.2.02.04 Хуримтлагдсан элэгдэл	(50,962,500.00)	(57,692,500.00)
	1.2.2.02.05 Машин тоног		
39205	төхөөрөмж(компьютер)	20,463,500.00	20,463,500.00
39206	1.2.2.02.06 Хуримтлагдсан элэгдэл	(19,514,500.00)	(20,463,500.00)
39207	1.2.2.02.07 Тавилга, аж ахуйн эд хогшил	1,770,000.00	1,770,000.00
39208	1.2.2.02.08 Хуримтлагдсан элэгдэл	(1,770,000.00)	(1,770,000.00)
39209	1.2.2.02.09 Зам, гүүрийн байгууламж	238,870,616.00	238,870,616.00
39210	1.2.2.02.10 Хуримтлагдсан элэгдэл	(218,898,514.78)	(223,898,514.78)
3	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	57,163,167.23	46,362,473.48
5	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	57,163,167.23	46,362,473.48
51	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	57,163,167.23	46,362,473.48
51200	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	57,163,167.23	46,362,473.48
51210	2.2.1.08.01 Өмнөх үеийн үр дүн	128,160,214.26	57,163,167.23
51220	2.2.1.08.02 Тайлант үеийн үр дүн	(70,997,047.03)	(10,800,693.75)
6	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	57,163,167.23	46,362,473.48

2.2 Аудит хийсэн орлого, үр дүнгийн дэлгэрэнгүй тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	28,592,500.00	5,221,367.00
12	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,592,500.00	5,221,367.00
120	1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	28,592,500.00	5,221,367.00
120004	1.1.1.04.1.04 Төсөв байгууллагын өөрийн орлого	28,592,500.00	5,221,367.00
1200041	1.1.1.04.1.04.01 Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,592,500.00	5,221,367.00
II	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	58,428,571.03	16,022,060.75
21	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	58,428,571.03	16,022,060.75
210	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	58,428,571.03	16,022,060.75
2101	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,000,000.00	-
210105	1.1.2.01.1.01.05 Гэрээт ажлын хөлс	5,000,000.00	-
2104	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	8,743,844.00	876,229.82
210402	1.1.2.01.1.04.02 Тээвэр, шатахуун	8,743,844.00	876,229.82
2106	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	-
210601	1.1.2.01.1.06.01 Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	-
2108	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	24,600.00
210813	1.1.2.01.1.08.13 Бусад зардал /ТӨҮГ/	-	24,600.00
2109	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	39,684,727.03	15,121,230.93
210901	1.1.2.01.1.09.01 Бараа үйлчилгээний бусад зардал	9,119,900.00	-
210903	1.1.2.01.1.09.03 Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,564,827.03	15,121,230.93
III	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(29,836,071.03)	(10,800,693.75)
V	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	41,160,976.00	-
225010	1.2.2.10 Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	41,160,976.00	-
VII	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(41,160,976.00)	-
VI	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(70,997,047.03)	(10,800,693.75)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	28,592,500.00	5,221,367.00
12	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,592,500.00	5,221,367.00
120	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	28,592,500.00	5,221,367.00
120004	1.1.1.1.04.1.04 Төсөв байгууллагын өөрийн орлого	28,592,500.00	-
1200041	1.1.1.1.04.1.04.01 Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,592,500.00	-
120009	1.1.1.1.04.1.09 Бусад орлого	-	5,221,367.00
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	27,863,744.00	900,829.82
21	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	27,863,744.00	900,829.82
210	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,863,744.00	900,829.82
2101	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,000,000.00	-
210105	1.1.1.2.01.1.01.05 Гэрээт ажлын хөлс	5,000,000.00	-
2104	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	13,743,844.00	876,229.82
210402	1.1.1.2.01.1.04.02 Тээвэр, шатахуун	8,743,844.00	876,229.82
210409	1.1.1.2.01.1.04.07 Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	5,000,000.00	-
2108	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	24,600.00
210818	1.1.1.2.01.1.08.13 Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	-	24,600.00
2109	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	9,119,900.00	-
210901	1.1.1.2.01.1.09.01 Бараа үйлчилгээний бусад зардал	9,119,900.00	-
III	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	728,756.00	4,320,537.18
VIII	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	728,756.00	4,320,537.18
101	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	728,756.00
20	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	728,756.00	5,049,293.18

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээ ний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	128,160,214.26	128,160,214.26
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	128,160,214.26	128,160,214.26
9	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	0	0	(70,997,047.03)	(70,997,047.03)
10	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	57,163,167.23	57,163,167.23
11	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	0	57,163,167.23	57,163,167.23
13	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	57,163,167.23	57,163,167.23
19	1.7 Тайлант үеийн үр дүн	0	0	(10,800,693.75)	(10,800,693.75)
20	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0	0	46,362,473.48	46,362,473.48

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар үйл ажиллагааны үр дүн, дотоод хяналттай холбоотой зөрчил¹ илэрсэнд 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1. Үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой.

Илрүүлэлт: Гурванзагал Хөгжил орон нутгийн өмчит газар сүүлийн 3 жил алдагдалтай ажилласан байна. Үр дүнгийн тайлан 2023 оны үйл ажиллагааны үр дүн -43.2 сая төгрөг, 2024 оны үйл ажиллагааны үр дүн -70.9 сая төгрөг, 2025 оны үйл ажиллагааны үр дүн -10.8 сая төгрөг./ Шалтгаан нь 2025 он үйл ажиллагаа явуулаагүй, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал гарсан, мөн өмнөх онуудад сумын ОНХС-гаас төсөл, хөтөлбөрийн санхүүжилт авч үйл ажиллагаа явуулахаас өөр орлого олоогүйтэй холбоотой байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн өмчит газрын үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.

3.1.2. Дотоод хяналттай холбоотой.

Илрүүлэлт: Гурванзагал сумын Засаг даргын 2025 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн Б/15 тушаалаар орон нутгийн өмчит газрын даргыг чөлөөлсөн байна. Орон нутгийн өмчит газарт дарга томилогдоогүй, жилийн эцсийн санхүүгийн тайланд сумын Засаг дарга гарын үсэг зурсан байна.

Өгсөн зөвлөмж: Өмчит газрын удирдлагыг томилох.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасан. Харин зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгүй ажилласан.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

СТ-нд Засаг дарга гарын үсэг зурсан	1	-	-	-	-	-	1	-	-	-	-
Дүн	2	-	-	-	-	-	2	-	-	-	-